

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2025/053/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Өлгий хот
2024 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Х.Еркебулан
Утас: 99427667 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 16 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 16 |
| 4.2 Материаллаг байдал | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 17 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 17 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 17 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 18 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 18 |
| 5.1 Төлбөрийн акт | 18 |
| 5.2 Албан шаардлага | 18 |
| 5.3 Зөвлөмж..... | 18 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 19 |
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 12 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 16 |
| 4.1 Ерөнхий зүйл..... | 16 |
| 4.2 Материаллаг байдал | 16 |
| 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 17 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 17 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 17 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 17 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар | 17 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 18 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 18 |
| 5.1 Төлбөрийн акт | 18 |
| 5.2 Албан шаардлага | 18 |
| 5.3 Зөвлөмж..... | 18 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ж.ТӨЛЕУХАН
ТАНАА

2025.02.28 № 300
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд 1,129.7 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,067.4 сая төгрөг зарцуулж, 94.4 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Булган сумын Засаг даргын тамгын газар Дүгнэлт

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Булган сумын Засаг даргын тамгын газар Дүгнэлт

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Төгрөгөөр | |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>100,518,606.54</u> | <u>72,158,121.18</u> |
| 33 | АВЛАГА | 6,854,075.94 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 6,854,075.94 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 93,664,530.60 | 72,158,121.18 |
| 351 | Түүхий эд материал | 236,200.00 | 236,200.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 236,200.00 | 236,200.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 233,652.00 | 233,652.00 |
| 354 | Хангамжийн материал | 93,194,678.60 | 71,688,269.18 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,718,000.00 | 1,639,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,706,869.00 | 10,598,269.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,059,009.60 | 7,143,000.18 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 72,710,800.00 | 52,308,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>1,860,681,874.22</u> | <u>1,826,424,228.83</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | <u>1,860,681,874.22</u> | <u>1,826,424,228.83</u> |
| 392 | Биет хөрөнгө | <u>1,841,964,686.41</u> | <u>1,807,495,624.10</u> |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 839,302,372.74 | 951,795,372.74 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (259,254,881.68) | (314,375,579.15) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 223,929,914.00 | 302,502,414.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (105,224,066.80) | (133,049,652.50) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 392,144,334.00 | 421,942,384.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (333,080,480.64) | (348,042,288.02) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 34,353,994.35 | 39,163,994.35 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (27,119,280.33) | (28,138,504.23) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 1,807,063,926.20 | 1,815,063,926.20 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (949,485,928.67) | (1,093,172,710.90) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 403,178,844.00 | 403,178,844.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (183,844,060.76) | (209,372,576.39) |
| 393 | Биет бус хөрөнгө | 18,717,187.81 | 18,928,604.73 |
| 39301 | Програм хангамж | 3,306,639.00 | 4,076,639.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,255,933.19) | (1,814,516.27) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,666,482.00 | 16,666,482.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>1,961,200,480.76</u> | <u>1,898,582,350.01</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | <u>55,720,915.40</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 55,720,915.40 |
| 413 | Өглөг | - | 55,720,915.40 |
| 4136 | Бусад өглөг | - | 55,720,915.40 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 55,720,915.40 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>1,961,200,480.76</u> | <u>1,842,861,434.61</u> |

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,961,200,480.76 | 1,842,861,434.61 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 850,148,776.35 | 850,148,776.35 |
| 51101 | Өмч: - төрийн | 850,148,776.35 | 850,148,776.35 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 234,751,616.47 | 116,412,570.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 234,751,616.47 | 234,751,616.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (118,339,046.15) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 876,300,087.94 | 876,300,087.94 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,961,200,480.76 | 1,898,582,350.01 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Төгрөгөөр | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,104,382,806.40 | 1,334,654,564.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 362,039,413.00 | 224,390,550.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 362,039,413.00 | 224,390,550.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 362,039,413.00 | 224,390,550.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 362,039,413.00 | 224,390,550.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 742,343,393.40 | 1,110,264,014.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,266,509.00 | 32,095,114.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,266,509.00 | 32,095,114.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 734,076,884.40 | 1,078,168,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 734,076,884.40 | 1,078,168,900.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,025,659,311.35 | 1,452,993,610.15 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,025,659,311.35 | 1,452,993,610.15 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 995,831,670.95 | 1,389,564,660.15 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 425,691,646.66 | 771,616,691.34 |
| 210101 | Үндсэн цалин | 308,945,846.66 | 454,480,991.34 |
| 210102 | Нэмэгдэл | 111,745,800.00 | 299,056,700.00 |
| 210104 | Урамшуулал | 5,000,000.00 | 18,079,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,278,200.00 | 93,477,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,229,200.00 | 63,564,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,262,200.00 | 7,478,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,409,800.00 | 3,739,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 852,500.00 | 3,739,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,524,500.00 | 14,956,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,801,045.40 | 31,116,009.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,349,762.00 | 1,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 35,451,283.40 | 29,616,009.42 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 41,309,539.80 | 60,567,814.00 |

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------------|--------------------------------|
| 210401 | Бичиг хэрэг | 3,307,260.00 | 3,156,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 33,461,429.80 | 52,499,114.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,850,900.00 | 3,742,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 689,950.00 | 470,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,107,280.00 | 699,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,107,280.00 | 699,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,855,900.00 | 4,256,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,085,000.00 | 1,613,400.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 143,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,770,900.00 | 2,500,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,954,100.00 | 14,853,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,954,100.00 | 14,853,200.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 70,985,120.00 | 98,727,350.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,059,200.00 | 97,344,150.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 50,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 365,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 383,920.00 | 492,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | 120,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 361,000.00 | 276,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 131,000.00 | 128,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 352,848,839.09 | 314,249,595.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,193,529.06 | 45,105,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 654,500.00 | 442,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 272,000,810.03 | 268,701,195.39 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29,827,640.40 | 63,428,950.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 714,000.00 | 52,640,880.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 21,650,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 28,355,980.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 714,000.00 | 2,634,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 29,113,640.40 | 10,788,070.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,113,640.40 | 10,788,070.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>78,723,495.05</u> | <u>(118,339,046.15)</u> |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>78,723,495.05</u> | <u>(118,339,046.15)</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 742,343,393.40 | 1,110,264,014.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 742,343,393.40 | 1,110,264,014.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,266,509.00 | 32,095,114.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,266,509.00 | 32,095,114.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 734,076,884.40 | 1,078,168,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 734,076,884.40 | 1,078,168,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 737,013,393.40 | 1,100,211,014.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 737,013,393.40 | 1,100,211,014.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 707,185,753.00 | 1,036,782,064.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 434,225,800.00 | 709,041,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 317,480,000.00 | 391,906,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 111,745,800.00 | 299,056,700.00 |
| 210104 | Урамшуулал | 5,000,000.00 | 18,079,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,348,200.00 | 93,477,800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,299,200.00 | 63,564,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,262,200.00 | 7,478,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,409,800.00 | 3,739,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 852,500.00 | 3,739,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,524,500.00 | 14,956,500.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 32,825,000.00 | 33,200,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,349,762.00 | 1,500,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 31,475,238.00 | 31,700,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 37,129,283.00 | 60,488,814.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,840,000.00 | 3,077,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,191,383.00 | 52,499,114.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,770,900.00 | 3,742,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 700,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 327,000.00 | 470,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 430,000.00 | 699,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 430,000.00 | 699,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,979,000.00 | 3,258,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 404,000.00 | 615,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 71,000.00 | 143,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,504,000.00 | 2,500,000.00 |
| 2107 | Томилот, зочны зардал | 10,954,100.00 | 14,808,900.00 |

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|----------------------------|-----------------------------|
| 210702 | Дотоод албан томилолт | 10,954,100.00 | 14,808,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 71,330,120.00 | 98,734,650.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,409,200.00 | 97,344,150.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 365,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 383,920.00 | 492,800.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 120,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 361,000.00 | 239,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 131,000.00 | 128,500.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 45,000.00 | 44,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,964,250.00 | 23,072,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 60,309,750.00 | 22,629,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 654,500.00 | 442,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 29,827,640.40 | 63,428,950.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 714,000.00 | 52,640,880.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 21,650,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 28,355,980.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 714,000.00 | 2,634,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 29,113,640.40 | 10,788,070.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 29,113,640.40 | 10,788,070.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>5,330,000.00</u> | <u>10,053,000.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 10,053,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 10,053,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 10,053,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 10,053,000.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | = | = |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 5,330,000.00 | |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,000,000.00 | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|-------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| С01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | | | | - |

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|-----|--|-----------------------|-----------------------|-----------------------|------------------|
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 850,148,776.35 | 876,300,087.94 | 341,333,021.17 | 2,067,781,885.46 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | (115,359,887.49) | (115,359,887.49) |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 850,148,776.35 | 876,300,087.94 | 234,751,616.35 | 1,961,200,480.64 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 850,148,776.35 | 876,300,087.94 | 234,751,616.35 | 1,961,200,480.64 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 850,148,776.35 | 876,300,087.94 | 234,751,616.47 | 1,961,200,480.76 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (118,339,046.15) | (118,339,046.15) |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 850,148,776.35 | 876,300,087.94 | 116,412,570.32 | 1,842,861,434.61 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-------------------------|-------------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,129,667,700.00 | 1,067,380,830.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,129,667,700.00 | 1,067,380,830.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,066,880,800.00 | 1,014,739,950.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 747,822,900.00 | 709,041,700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 403,906,000.0 | 391,906,000.0 |
| 210102 | Нэмэгдэл | 323,837,900.0 | 299,056,700.0 |
| 210104 | Урамшуулал | 20,079,000.0 | 18,079,000.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 93,477,800.0 | 93,477,800.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,564,900.0 | 63,564,900.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,478,200.0 | 7,478,200.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,739,100.0 | 3,739,100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,739,100.0 | 3,739,100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,956,500.0 | 14,956,500.0 |

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|------------------------|------------------------|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,200,000.0 | 33,200,000.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,500,000.0 | 1,500,000.0 |
| 210302 | Түлш, халаалт | 31,700,000.0 | 31,700,000.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 39,547,800.0 | 39,543,100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,082,000.0 | 3,077,300.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,942,300.0 | 31,553,400.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,353,500.0 | 3,742,400.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 700,000.0 | 700,000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 470,000.0 | 470,000.0 |
| 2105 | Нормативт зардал | 700,000.0 | 699,600.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 700,000.0 | 699,600.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,256,600.0 | 4,256,600.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,613,400.0 | 1,613,400.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 143,200.0 | 143,200.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.0 | 2,500,000.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 13,910,400.0 | 13,618,900.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,910,400.0 | 13,618,900.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 113,215,200.0 | 100,771,650.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 110,569,700.0 | 99,344,150.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 513,000.0 | 0.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 365,500.0 | 365,500.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 492,800.0 | 492,800.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,400.0 | 120,400.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 981,000.0 | 276,000.0 |
| 210807 | Газрын төлбөр | 128,500.0 | 128,500.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 44,300.0 | 44,300.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,750,100.0 | 20,130,600.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,688,100.0 | 19,688,100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,062,000.0 | 442,500.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,786,900.0 | 52,640,880.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 62,786,900.0 | 52,640,880.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,650,900.0 | 21,650,900.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 38,502,000.0 | 28,355,980.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,634,000.0 | 2,634,000.0 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,129,667,700.0 | 1,067,380,830.0 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 0.0 | 0.0 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,129,667,700.0 | 1,067,380,830.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,129,667,700.0 | 1,067,380,830.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

| | | | |
|-----------|--|--------------|--------------|
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 27.00 | 28.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 3.00 | 3.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 16.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 4.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 5.00 | 5.00 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 27.00 | 28.00 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.00 | 9.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10.00 | 11.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 5.00 | 5.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 3.00 | 3.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 32,095,114.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 32,095,114.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 32,095,114.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,945,714.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,945,714.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,190,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,190,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,959,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,959,400.00 |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 32,095,114.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 32,095,114.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 32,095,114.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Булган сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд

үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

Булган сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн үндэстэн ястны онцлогт тулгуурласан хамтын үнэт зүйл, хөгжил тэмүүлэл, соёлын олон илэрхийллийг тэгш харуулсан, оновчтой зохион байгуулалт менежмент бүхий төрийн захиргааны мэргэжлийн байгууллага байх гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Булган сумын Засаг даргын тамгын газар нь Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд дотоод аудитын шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Булган сумын Засаг даргын тамгын газрын даргын 2023 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн А/08 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна. Энэхүү нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан хууль эрхийн актуудтай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2023 оны 229 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62.6 сая төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|----------------------------|----------------------------|--------------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 6,854.08 | 0.00 | -6,854.08 |
| Урьдчилгаа | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 93664.53 | 72158.12 | -21506.41 |
| Үндсэн хөрөнгө | 1860681.87 | 1826424.23 | -34257.65 |
| Нийт хөрөнгө | <u>1,961,200.48</u> | <u>1,898,582.35</u> | <u>-62,618.13</u> |
| Өр төлбөр | 0.00 | 55,720.92 | 55,720.92 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1961200.48 | 1842861.43 | -118,339.05 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | <u>1,961,200.48</u> | <u>1,898,582.35</u> | <u>-62,618.13</u> |

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө, урьдчилгаа дансанд өөрчлөлт гараагүй. Дансны авлагаын оны эхний 6.8 сая төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын данс оны эхэнд 93.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр нийт 108.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 50.9 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй хүлээн авч, 181.4 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 72.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 1,860.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 29.9 сая төгрөгийн төсвийн хөрөнгөөр худалдан авч, 196.4 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, оны эцэст 1,847.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Өглөг дансны оны эцэст 55.7 сая төгрөгийн НДШ, ХАОАТ-ын өглөгтэй байна.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 118.3 сая төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр зарлагын нийт дүнг 920.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 129.5 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 28.1 сая төгрөгөөр нийтдээ 157.6 сая төгрөгөөр нэмж, нийт төсвийг 1,078.2 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 157.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,078.2 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,129.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжилт авахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,078.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, жилийн эцэст 10.8 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,067.4 сая төгрөг буюу 94.4 хувьтай байна. Төсвөөс 62.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--------------------|---|--------------------|--------------------|-----------------|-------------|
| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 722,605.4 | 683,551.3 | 39,054.1 | 94.6% |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 234,569.2 | 232,708.0 | 1,861.2 | 99.2% |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 62,786.6 | 52,640.9 | 10,145.7 | 83.8% |
| 4 | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 109,706.2 | 98,480.7 | 11,225.5 | 89.8% |
| | Дүн | 1,129,667.4 | 1,067,380.8 | 62,286.5 | 94.4 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлийн судалгааны дүн дараах байдалтай байна. Үүнд:

Сумын ЗДТГазар нь цалингийн сангаас ахмадын санд мөнгө төвлөрүүлж, зарцуулаагүй байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй байна.

Төсвөөс 2024 онд бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн /210801/ төсвөөс 97.3 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардлын /210901/ төсвөөс 22.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сумын ЗДТГазарт 2024 онд 27 орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр удирдах ажилтан 3, гүйцэтгэх ажилтан 16, үйлчлэх ажилтан 4, гэрээт ажилтан 5 нийтдээ 28 орон тоогоор батлагдсан орон тоо, төсөвт багтаан ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Булган сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд Статистикийн хэлтсээс 6.1 сая төгрөгийн, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 18.8 сая төгрөгийн, бусад орлогоос сая төгрөгийн 7.2 сая төгрөгийн нийтдээ 32.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хүлээн авсан байна. Үүнд: Мал тооллогын зардалд 6.1 сая төгрөг, Ковш-50 маркийн тракторын зардалд 2.0 сая төгрөгийг, 4.0 сая төгрөгийн ахмадын баярын зардалд, 1.1 сая төгрөгийг шагналын зардалд, 18.9 сая төгрөгийг гамшгийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркебулан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,025.8 сая төгрөгөөс буюу 15.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх шатанд материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,452.9 2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 21.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор нэмэгдэл цалин, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардлыг нийтдээ 10.8 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгасан.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийтдээ 627.8 сая төгрөгийн 28 мөнгөн гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 157.9 сая төгрөгийн 12 мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 68.1 сая төгрөгийн 10 мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100 хувьтай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар алдаа, зөрчил илрээгүй тул нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар эхний хагас жилийн баримтыг хүлээн авч түүвэр сорил хийсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эрсдэлтэй гэж сонгосон данисуудад горим сорил хэрэгжүүлж, төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийн шалгалтаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар нийт 2.8 сая төгрөгийн зөрчил илэрч 2.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, нэг зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 2,835.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор Сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 10 өдрийн Б/13 дугаар захирамжаар тамгын газрын даргад 8,754,980 төгрөгийн, Тамгын газрын даргын 04 дүгээр сарын 10 өдрийн Б/08 дугаар тушаалаар хөдөө аж ахуйн мэргэжилтэнд 6,137,200 төгрөгийн, 2024 оны 04 сарын 10 өдрийн Б/08 дугаар тушаалаар нийгмийн бодлогын мэргэжилтэнд 6,137,200 төгрөгийн, мөн Тамгын газрын даргын 04 дүгээр сарын 10 өдрийн Б/08 дугаар тушаалаар байгаль орчны байцаагчид 7,326,600 төгрөгийн мөнгөн урамшууллаас нийтдээ 2,835,598 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно”, 6.1.19-д “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7-д “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллаас суутгаагүй 2,835,598 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Булган сумын Засаг даргын тамгын газар нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй /түлш шатах тослох материал 52.5 сая төгрөг, худалдан авсан г.м/ байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.1-т Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.”, 46.1-т “Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана.” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--|-------------|----------------|---------------|----------------|-----------------|-----|----------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | | | | | | | Тоо | Дүн | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллаас суутгаагүй | 1 | 2,835.6 | 1 | 2,835.6 | | | | | | | | |
| Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлээгүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 2 | 2,835.6 | 1 | 2,835.6 | | | 1 | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|--------------------|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | | | | | Тоо | Дүн |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | | | |
|--|--|--|--|--|--|--|--|--|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |